



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 14

Сүхбаатар сум

“Сэлэнгэ үйлчилгээ” Орон нутгийн өмчит аж ахуйн
тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгах тухай

Аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 44 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Сэлэнгэ үйлчилгээ” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот, үйлдвэрийн газар болон Сүхбаатар сумын “Сүхбаатар хөгжил тохижилт” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот, үйлдвэрийн газруудаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь Сүхбаатар сумын ард иргэдийн ая тухтай, эрүүл аюулгүй тайван орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн ижил төсөөтэй чиг үүрэг зорилготой байгааг харгалзан Сүхбаатар сумын тохижилт үйлчилгээ, гудамж талбайн гэрэлтүүлэг, хог хаягдал цэвэрлэгээний ажлын менежментийг сайжруулж, чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор дээрх байгууллагуудыг нэгтгэх нь зүйтэй байна.


Иймд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 44 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Сэлэнгэ үйлчилгээ” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот, үйлдвэрийн газрын үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

Хоёр. Татан буугдсан “Сэлэнгэ үйлчилгээ” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот, үйлдвэрийн газрын хөрөнгийг Сүхбаатар суманд шинээр байгуулагдсан “Сүхбаатар хөгжил тохижилт” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот, үйлдвэрийн газарт холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шилжүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт даалгасугай.

00.00046

Гурав. “Сэлэнгэ үйлчилгээ” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот, үйлдвэрийн газрын чиг үүрэг, хөрөнгө шилжсэнтэй холбогдуулан Сүхбаатар сумын “Сүхбаатар хөгжил тохижилт” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот, үйлдвэрийн газрын үйл ажиллагааны дүрэм, чиг үүрэг, бүтэц орон тоог шинэчлэн баталж үр ашигтай, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллахыг Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА  Г.БЯМБАА

